

ГаХ №01(04) Гадаад худалдаа


Манай улс 2010 оны 1 дүгээр сард дэлхийн 70 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 295.5 сая ам.доллар, үүнээс экспорт 163.5 сая ам.доллар, импорт 132.0 сая ам.долларт хүрчээ (Зураг 1). Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 5.6 сая ам.доллар буюу 1.9 хувь, үүний дотор импортын хэмжээ 12.5 сая ам.доллар буюу 10.4 хувиар өссөн бол экспортын хэмжээ 6.9 сая ам.доллар буюу 4.0 хувиар буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны 1 дүгээр сард 31.5 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 19.4 сая ам.доллар буюу 38.1 хувиар багасчээ.

Нийт экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс буурахад боловсруулаагүй алтны биет хэмжээ 90.5 хувь, үнийн дүн нь 89.3 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.


Зураг 1

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая ам.доллар




Зураг 3

Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Зураг 2

Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2010 оны 1 дүгээр сарын байдлаар



Экспорт

Манай улс 2010 оны 1 дүгээр сард нийт 30 оронтой экспортын худалдаа хийж, экспортын худалдааны 84.6 хувийг БНХАУ-тай, 7.0 хувийг Канад улстай, 3.1 хувийг ОХУ-тай, 1.4 хувийг БНСУ-тай, 1.3 хувийг ХБНГУ-тай, 0.8 хувийг Итали улстай хийсэн нь нийт экспортын үнийн дүнгийн 98.2 хувийг эзэлж байна (Зураг 2).

Нийт экспортод зэсийн баяжмал 36.3 хувь, нүүрс 18.1 хувь, цайрын хүдэр, баяжмал 9.2 хувь, боловсруулаагүй нефть 8.3 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 7.0 хувь, төмрийн хүдэр 3.9 хувь, самнасан ноолуур 2.0 хувь, жоншны хүдэр, баяжмал 1.2 хувь, бусад бүтээгдэхүүн 14.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт экспортод зэсийн баяжмалын эзлэх хувь 19.9 пунктээр, нүүрснийх 18.0 пунктээр, цайрын хүдэр, баяжмалынх 7.7 пунктээр, боловсруулаагүй нефтийнх 7.3 пунктээр, төмрийн хүдрийнх 1.9 пунктээр өссөн бол боловсруулаагүй алтных 55.7 пунктээр, самнасан ноолуурынх 1.5 пунктээр, жоншны хүдэр, баяжмалынх 0.6 пунктээр, бохир ноолуурынх 0.4 пунктээр тус тус буурчээ.

Экспортын үнийн дүнгийн 96.9 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл эзэлж байна (Зураг 3).